

ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБООНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА БА МОНГОЛ УЛС: ТЭМҮҮЛЭЛ, СОРИЛТ

Д.Уламбаяр*
Т.Уянгаа**

***Abstracts:** : Today the issues such are, firstly, adaptation to the global warming and climate change, secondly, adaptation to digitalization world, and as well as thirdly, adaptation to process of the new multi-polar world order formation of international relations, are becoming key challenges for nations. At the present, Mongolia is located at gravitational center of the new multi-polar world order formation stage. In general, the bilateral and multilateral free trade agreements and process of economic integration are facing numerous key challenges in the globalization. Mongolia's exporting capacity is limited and competition is weak. Therefore, it is recommended to change Free Trade Agreement into Economic Partnership Agreement.*

***Keywords:** The Eurasian Economic Union, Economic Diplomacy, Free Trade Agreement, new multi-polar world order, Economic Partnership Agreement.*

* * *

Олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явц

Дэлхийн шинэ дэг журам хэмээх категори (ай) улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцаа, геополитикийн үндсэн ухагдахуунуудын нэг мөн билээ. Энэхүү улс төрийн нэр томъёо үүсэл гарлын хувьд 1776 онд буй болсон АНУ-ын Төрийн Их тамганы дардас дээр латин хэлээр «ANNUIT COEPTIS: NOVUS ORDO SECLORUM» гэж бичсэн нь “Эрин үеийн шинэ дэг журмыг Тунхаглан зарлах нь” гэснээс үүдэлтэй. 1935 онд анх гүйлгээнд гарсан АНУ-ын нэг долларын шинэ дэвсгэртийн ар талын нүүрэнд дээрх тамгын дардас хэвлэгдэн гарснаас хойш үргэлжлэн хэвлэгдэж өнөөг хүрчээ.

XX зууны түүхийн огцом өөрчлөлтүүд, түүнтэй гүн гүнзгий холбоотой улс төрийн сэтгэлгээ болон орчин үеийн олон улсын харилцааны онолын хөгжилтэй уялдан энэхүү нэр томъёо олон улсын харилцааны үзэл баримтлалын шинжтэй цогц ойлголт болон гарч ирэв. *Дэлхийн дэг тогтолцоо* хэмээх ойлголтын мөн чанар нь эмх замбараагүй, хуваагдмал, олон янз, үндэсний явцуу үзэл баримтлалд суурилсан хуучин олон улсын харилцааг хүний эрх, эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засаг, олон улсын эрхзүйн хэм хэмжээнд тулгуурлан илүү зохистой глобал засаглалаар илбэн тохинуулах замаар өнөөгийн дэлхий ертөнцийг өөрчлөн байгуулах тухай асуудал юм.²²¹

Эдүгээ *нэгд*, харилцан шалтгаалцал, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж, тиймээс ойрх

* ХУИС-ийн Олон Улсын Харилцаа, Нийгэм Судлалын Сургуулийн захирал, Профессор

** Монгол, ЕХ-ны түншлэлийг дэмжих нийгэмлэгийн төслийн судлаач

²²¹ Д.Уламбаяр. «Дэлхийн шинэ дэг журмын талаарх зарим эргэцүүлэл»- “*Стратегийн судалгаа*” сэтгүүд. ССХ. УАБЗ, №68 4/2014, 128-137 дахь тал

ирээдүйн төлөв байдлыг ч урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов. *Хоёрт*, эдүгээ олон улсын хамтын ажиллагааны хамгийн чухал зүйл нь олон улсын эрхзүйн хэм хэмжээнд дэлхийн улс орнуудын тогтвортой байдлыг хангах, олон улсын харилцаа, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг хадгалах явдал тулгамдсан асуудал болсоор байна. *Гуравт*, хүчний тэнцвэрийг барихаас гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болов. Тийнхүү бие биенийхээ эрх ашигт хэрхэн нөлөөлөхгүй байх тухай асуудал чухал болов. *Дөрөвт*, төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын харилцааны шинэ дэг журам төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бүрхэг байгаа зэрэг санал, дүгнэлтүүд юм. Brexit, АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараах шинэ нөхцөл байдал, ШХАБ, Евразийн эдийн засгийн холбоо, Торгоны их замын мега төслийн үйл явц үүний тод илрэл юм.

Улс орнуудын өмнө дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, даяаршиж буй дижитал ертөнцөд дасан зохицохоос гадна, олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад нэгэн адил хэрхэн дасан зохицох тухай асуудал шинээр дэвшигдэн тавигдаж байна. Олон туйлт дэлхийн шинэ бодлогын үзэл санаа анхлан 1997 оны 4 дүгээр сарын 23-нд Москвад гарын үсэг зурсан «Олон туйлт ертөнц, олон улсын шинэ дэг журмыг цогцлоон байгуулах тухай Орос-Хятадын Хамтарсан Тунхаглалд»²²² тусгалаа олсон юм. Энэхүү үзэл санаа ШХАБ, БРИКС-ийн орнуудын дээд уулзалтын баримт бичгүүдэд тусгалаа олсоор ирэв.²²³

ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров Монгол Улсын ГХЯ-нд хийсэн уулзалтан дээр тэмдэглэхдээ: «Дэлхий ертөнц өнөөдөр түүхэн шинэ эрин үед шилжин орох үе шатандаа ирээд байна. Энэ бол бидний хийж буй ул суурьтай дүгнэлт юм. Өнөөдөр олон улсын харилцааны олон төвт бүтэц бий болж байна. Сүүлийн жилүүдэд өрнөж буй үйл явдлууд нь нэг туйлт ертөнц бий болгох оролдлого хийгээд дэлхий дахинд ганцаар давамгайлах хүсэл эрмэлзэл нь төөрөгдөлд хүргэдэг болохыг харуулж байна. Өнөөгийн нөхцөл байдалд дэлхийн аль ч улс орон, хамгийн хүчирхэг нь байлаа ч тэр, хэсэг бүлэг орнууд байгаад ч тэр орчин цагийн тулгамдсан асуудлуудыг дангаараа үр дүнтэйгээр шийдвэрлэх гэж оролдоод ч нэмэргүй нь илт болжээ. Ийм нөхцөл байдал үүссэн үед бүгдэд тулгарч буй асар том сорилт хийгээд аюул заналд оновчтой хариу барих үүднээс дэлхийн тавцан дахь үндсэн гол тоглогчдын жинхэнэ бодитой түншлэлд тулгуурлан үндэсний эрх ашиг болон хамтын дипломат үйл ажиллагааны хоорондох ухаалаг тэнцвэрийг эрж хайх нь чухал боллоо»²²⁴ гэжээ. Бид олон улсын харилцааны олон

²²² Российско-Китайская совместная декларация о многополярном мире и формировании нового международного порядка. Москва, 23 апреля 1997 года (текст документа с изменениями и дополнениями по состоянию на ноябрь 2007 года)

²²³ 2016 оны 10 дугаар сарын 16-нд Энэтхэгийн Гоа мужид зохиогдсон БРИКС-ийн дээд уулзалтаас гаргасан Гоагийн Тунхаглалд: "...зөвхөн олон улсын эрхзүйг дээдэлж, НҮБ-ын гол үүрэгт суурилсан олон туйлт олон улсын дэг тогтолцоог цогцлоон байгуулах" тухай заасан байна.

²²⁴ Выступление и ответы на вопросы Министра иностранных дел России С.В.Лаврова на встрече в МИД Монголии, Улан-Батор, 14 апреля 2016 года

туйлт дэлхийн шинэ дэг журамд дасан зохицож, урагш алхах шаардлагатай.

ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхиж байгаа нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын харилцааны дэг журам, аюулгүй байдлын системд ноцтой нөлөө үзүүлж эхлэв хэмээн судлаачид үзсээр байгаа юм. Улс хоорондын харилцаанд шашин болон үндэстэн хоорондын мөргөлдөөн, олон улсын терроризм, иргэний дайн, газар нутгийн маргаан, дүрвэгсэдийн давалгаа, цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөрөөр далайлгах, эдийн засгийн хориг арга хэмжээ өргөжиж, их гүрнүүдийн хоорондох ашиг сонирхлын зөрчил хурцдах төлөвтэй болж, тиймээс хүйтэн дайн дууссаны дараах үе төгсгөл болж, шинэ хүйтэн дайны үе эхэллээ хэмээн тэмдэглэх нь ч буй. Хэдийгээр их гүрнүүдийн цэргийн зардал нэмэгдэж байгаа ч энэ нь дайн гарах гол үндэслэл биш, харин аюулгүй байдлаа баталгаажуулж буй хэрэг, их гүрний байр суурь, сүр хүчээ харуулж буй хэрэг, хүчний дахин тэнцвэржүүлэлт, мөн орлогын чухал эх сурвалж юм.

Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багасаж байна. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, хил хязгааргүй эдийн засгийн нэгдсэн нэг орон зай болсон байна.

Бид нэгд, Олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцад гурвалсан хөршийн бодлого, “гуравдагч хөрш”-ийн бодлогын хооронд хүчний тэнцвэр, эрх ашгийн тэнцвэрийг зөв барих явдал чухал боллоо. *Хоёрт*, Монгол Улсын гадаад орчин 1990-ээд оноос үндсээрээ өөрчлөгдсөн гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. *Гуравт*, Өрнөдийн хориг арга хэмжээтэй холбоотойгоор ОХУ-ын Алс Дорнодын бодлого, ялангуяа БНХАУ-ыг чиглэсэн бодлого идэвхижсэн нь Монгол Улсын геополитикийн ач холбогдлыг мэдэгдэхүйц өсгөв. Бид үүнийг дорвитой ашиглаж чадаагүй л байна. *Дөрөвт*, Орос, Хятадын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн багтай түвшинд хүрсэн нь²²⁵ (*Россия и Китай выходят на новый уровень отношений-уровень всеобъемлющего стратегического партнерства*) Монгол Улсын гадаад хамгийн ойр орчин сайн байна гэсэн үг. БНХАУ Хятад-Оросын харилцаа хэзээ ч холбоотны харилцаанд эргэж очихгүй гэж мэдэгдсэн билээ.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин «Дорнод дахь Оросын шинэ хэтийн төлөв» хэмээх томоохон өгүүлэл бичсэн нь зөвхөн Евразид төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг татсан юм. Түүнд: «Орос орон өөрийгөө Евразийн улс гэдгээ ямагт мэдэрсээр ирсэн. Оросын газар нутгийн үндсэн хэсэг нь Ази тивд оршдог гэдгийг бид хэзээ ч мартаж учиргүй. Харин энэ давуу талаа бүрэн ашиглаж чадаагүйг шударгаар хэлэх нь зүйд нийцнэ. Цаашлаад Ази-Номхон далайн бүс нутагт Орос улсын явуулах бодлого маш тодорхой. Дотоодын эрс өөрчлөлтийн үеийг


²²⁵ В.Путин 2012 оны 3 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгчөөр гуравдахь удаагаа сонгогдсоны дараа гадаад анхны айлчлалаа мөн оны 6 дугаар сард БНХАУ-аас эхэлж, хоёр орны бүх талыг хамарсан стратегийн түншлэл (*Россия и Китай выходят на новый уровень отношений-уровень всеобъемлющего стратегического партнерства*)-ийг шинэ түвшинд хүргэх тухай Бээжингийн Тунхаглалд гарын үсэг зурсан юм.

даван туулж буй манай улс бүс нутгийн байдлыг ерөнхийд нь эрчимжүүлэх, *уг бүс нутагт тогтвортой, урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг хадгалахыг сонирхож байна.* Орос улсын хувьд энэ бүс нутгийг манай нэгэн гэр бүл болгох үйл явцад идэвхитэй оролцох шинэ хэтийн төлөв Дорно зүгт нээгдэж байна»²²⁶ хэмээн үзжээ.

Бүр ХХ зууны эхээр II Николай хааны хамгийн ойрын зөвлөх, дипломатч, дорно дахин судлаач ван Эспер Эсперович Ухтомский (1861-1921) тэрбээр 1886-1996 онд Сибирь, Их Хүрээ, Манжуурт нэг бус удаа томилогдон ажиллаж байсан бөгөөд Их Оросыг Алс Дорнодод онцгой үүрэг гүйцэтгэх тухайд бичихдээ: *“Бүхий л үеийн туршид оросууд бид Азийн хэсэг байсаар ирсэн. Газарзүйн энэхүү онцлог байрлалынхаа улмаас бид Дорнын буурай хөгжилтэй ард түмнүүдийг хошуучлан оройлох хувьтай ажгуу. Энэ чухал үед оросууд Чингис хаан болон Доголон Төмөр хаанаас бидэнд гэрээслэн үлдээсэн өвийг хүлээн авах учиртай”* гэжээ. Э.Ухтомский Алс Дорнодод Оросын эрх ашгийг илэрхийлж, худалдаа-эдийн засгийн чиглэлд хувьцаат нийгэмлэг Орос-Хятадын банк, ДХТЗ, “Монголор” уурхайн нийгэмлэг, судалгааны чиглэлд “Оросын Эзэн хааны газарзүйн нийгэмлэг”, хэвлэл мэдээллийн тухайд «Санкт-Петербургские Ве домости»-г хариуцан идэвхтэй ажиллаж байсан юм.²²⁷ Харин “Орос орон Европын эсрэг зогсох юм бол мухардалд орно гэдгийг бид харсан. Хятадтай хамтраад хөгжинө гэж байхгүй, зөвхөн Европтой түншлэх юм бол хөгжих зам байгаа гэж бодож байна” гэж Яблоко фракцийн тэргүүн др. Г.Явлинский тухайн үедээ тэмдэглэж байв.²²⁸

Эцэст нь, Монгол Улс олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцын татах хүчний яг төвд нь оршиж байна.

Бүдүүвч 1.



²²⁶ Статья Президента России Владимира Путина «Россия: новые восточные перспективы» 9 ноября 2000 года

²²⁷ Д.Уламбаяр. Монгол Улс, Алс Дорно дахин: Олон улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. ХХ зууны эхнээс ХХI зууны эхэн. Тэргүүн боть. УБ.: 2013, 147-148 дахь тал

²²⁸ Лидер партии Яблоко-др. Григорий Явлинский отвечает на вопросы журналист А.Пашинин

Монгол Улс дэлхийд хамгийн том газар нутагтай, мөн хамгийн олон хүн амтай цөмийн зэвсэгтэй, өөр өөр онцлог бие даасан байр суурьтай хоёр гүрний дунд оршдог, үүгээрээ цорын ганц гэж хэлж болохоор, түүнчлэн далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, хөгжлийн тусламж горилогч, буурай хөгжилтэй орон байсан бол эдүгээ хоёр аварга баавгай, аварга лууны дунд орших galloper (жороолж буй чандаст хүлэг) гэж хэлж болохоор, өөрөөр хэлбэл дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний мэдэгдэхүйц нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, их гүрнүүдийн болон үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн геополитик, геоэдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулж байна. Монгол Улсыг хоёр гүрний хооронд хавчуулагдсан sandwich, бага жижиг улс, дэлхийн зах зээлээс алслагдсан, далайд гарцгүй, хөгжлийн тусламж горилогч гэх мэтээр нэрлэж байсан геополитикийн томъёолол үндсэндээ хуучирч байна.

Өнгөрсөн жилүүдэд засаглалын чанарын доройтол, ардчиллын нэрээр халхавч хийн улс төржсөн хийрхэл, шинжлэх ухаанд суурилаггүй төсөв, мөнгө, хөрөнгө оруулалт, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын алдаанууд бидэнд маш том сургамж болов.

ЕАЭЗХ-ны үйл ажиллагааны тэлэлт

ОХУ-ын Алс Дорнод, юуны өмнө БНХАУ руу чиглэлсэн эдийн засгийн дипломат ажиллагаа Крымын хойгийг өөртөө нэгтгэсэнтэй холбоотойгоор Өрнөдийн гүрнүүдийн эдийн засгийн хориг арга хэмжээний дараа эрс идэвхжив. Эдгээр нь *нэгд*, БНХАУ руу чиглэсэн хоёрт талт хамтын ажиллагааны хүрээнд, *хоёрт*, ШХАБ-ын хүрээнд, *гуравт*, БРИКС-ийн хүрээнд, Евразийн эдийн засгийн холбооны хүрээнд (ЕАЭЗХ) Торгоны замын нэг зам, бүслүүрийн мега төсөлтэй нягт интеграцчилах чиглэлээр явагдаж байна.

2014 оны 5 дугаар сарын 29-нд Казахстаны нийслэл Астана хотод Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ) байгуулах гэрээнд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин, Казахстаны Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев, Беларусийн Ерөнхийлөгч Александр Лукашенко нар гарын үсэг зурснаар гурван улс 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн гаалийн нэг тарифтай, нэгдсэн зах зээл албан ёсоор эхлэхээр болов.

Гэрээнд гарын үсэг зурсны дараа В.Путин хэлэхдээ: ЕАЭЗХ нь ЗХУ-ын задарлаас хойш 180 сая хүн амыг багтаасан орон зайд буй болж байгаа анхны эдийн засгийн томоохон нэгдэл юм гэдгийг онцолсон байна. Тэрбээр гишүүн орнуудын тусгаар тогтнолыг хүндэтгэж үзэхээ мөн илэрхийлсэн юм. Н.Назарбаев ЕАЭЗХ нь ЗХУ-ыг буцаан сэргээх гэсэн оролдлого биш бөгөөд дэлхийн эдийн засагт тэргүүлэх үүрэгтэй цэвэр эдийн засгийн холбоо байна гэдгийг онцолсон байна. Гэрээ харилцан зөвшилцлийн үндсэн дээр байгуулагдаж байгаа ба ямар нэгэн албадлагын шинж чанар байгаагүйг ч тэмдэглэжээ. Ийм холбоо байгуулах санааг 20 жилийн өмнө Нурсултан Назарбаев гаргаж байжээ. А.Лукашенко ЕАЭЗХ

байгуулах үйл явц амар хялбар байгаагүйг дурдсан байв. Үнэндээ 20 гаруй жил дуншиж байж гэрээнд гарын үсэг зурсан юм. Хэлэлцээний шатнаас Крымийн хойгийг ОХУ өөртөө хүч түрэн нэгтгэсэнтэй холбоотойгоор Украин татгалзсан бол Армени, Кыргызстан улсууд нэгдэх хүсэлтээ илэрхийлсэн байна. А.Лукашенко бээр Украиныг хэзээ нэгэн цагт нэгдэнэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлсэн юм. Энэ холбоог Европын Холбооны гол өрсөлдөгч болно гэж шинжээчид үзэж байв. “ЕАЭЗХ нь өрнөдийн эсрэг гэхээсээ илүүтэй Хятадын эсрэг хүчээ нэгтгэж байгаа юм” гэж олон улсын тоймчид таамагласан байна. Үүнтэй холбогдуулан ОХУ-аас Монгол Улсад Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд И.К.Азизов, Казакстан улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд К.Кобландин нар хамтарсан хэвлэлийн бага хуралд мэдээлэл хийсэн юм.

Эдийн засгийн Дээд Зөвлөлийн ээлжит хуралдаанаар ОХУ, Беларусь, Казахстан улсууд ЕАЭЗХ-ны тухай гэрээ байгуулав. Ингэснээр гурван улс эдийн засгийн салбарт нэг шугаман дээр зогсч, хоорондын бараа таваар, ажил үйлчилгээ, эд хөрөнгө, ажиллах хүчийг чөлөөтэй солилцохоос гадна эрчим хүч, ХАА, үйлдвэр, зам тээврийн салбар дахь бодлогоо харилцан зөвшилцөх үүрэг хүлээжээ. ЕАЭЗХ байгуулагдсанаар гурван улсын гааль хоорондоо нээлттэй болж, гишүүн улсуудын нутаг дэвсгэрт эдийн засгийн хөгжлийн хүчирхэг шинэ төв 180 сая хүн амтай нэгдсэн зах зээл буй болж байгаа талаар элчин сайд К.Кобландин хэлсэн юм. Энэхүү холбоонд улс орнууд гишүүн болж орох нь нээлттэй бөгөөд Монгол Улсын хувьд ч өргөн боломж буй талаар ОХУ-ын элчин сайд И.К.Азизов онцлов. 2016 онд эм, анагаах ухааны бүтээгдэхүүний нэгдсэн зах зээл буй болов. Одоогоор тус холбоонд 40 гаруй улс элсэх сонирхолтой байгаагийн дотор БНХАУ, Энэтхэг, Турк, Израиль, Шинэ Зеланд, АСЕАН зэрэг томоохон эдийн засагтай улс, холбоод байгаа ажээ.

ЕАЭЗХ-ны гэрээ 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж, 180 сая хүн ам бүхий асар том орон зайг нэгтгэж зангидсан холбоо үйл ажиллагаагаа эхлэв. Дурьдсан үзүүлэлтээр ЕАЭЗХ нь дэлхийд долоод, харин газар нутгийн хэмжээгээр нэгд, ДНБ-ий хэмжээ 2.2 их наяд ам.доллар, энэ нь дэлхийд тавдугаар байрт орох үзүүлэлт болж байгаа ажээ. Дэлхийн хуурай газрын зургааны нэгийг эзэлж байсан хуучин ЗХУ-ын орон зайд ийнхүү ОХУ, Беларусь, Казахстан тэргүүтэй орнууд эдийн засгийн хөгжлийн шинэ төвийг байгуулав. 2015 онд Армян, Кыргызстан улсууд ЕАЭЗХ-д элсэв.²²⁹ Тажикстан ойрын хугацаанд гишүүнээр элсэх талаар яриа хэлэлцээ явагдаж байгаа юм. 2017 оны 4 дүгээр сард Кыргызстаны Бишкек хотноо зохиогдсон ЕАЭЗХ-ны дээд уулзалтаар Молдав улсыг ажиглагч гишүүнээр элсүүлэв.²³⁰

ЕАЭЗХ-ны төв оффис Москвад, санхүүгийн зохицуулах төв Алма-Атад, холбооны шүүх Минскт байрлаж байгаа юм. ЕАЭЗХ болон БНСВУ-ын хооронд байгуулсан чөлөөт худалдааны бүсийн хэлэлцээр 2016 оны 10 дугаар сарын 5-нд

²²⁹ Армен 2015.01.02, Кыргызстан 2015.08.12-нд элсчээ.

²³⁰ 2017 EEU Summit in Bishkek: Outcome of Meeting. <http://en.ctv.by/en/1492338017-2017-eeu-summit-in-bishkek-outcome-of-meeting>

хүчин төгөлдөр үйлчилж эхлэв. Энэхүү механизм хэрэгжиж эхэлснээр 94 сая хүн амтай, 650 орчим тэрбум ам долларын ДНБ (PPP) үйлдвэрлэл бүхий социалист Вьетнам улсын хувьд ОХУ, Армени, Беларусь, Казахстан, Кыргызстан гэсэн таван улсын зах зээлд чөлөөтэй нэвтрэх боломжтой болж байна.²³¹

Чөлөөт худалдааны бүсийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор зөвхөн Орос-Вьетнамын худалдааны эргэлт 2020 он гэхэд 10 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгаа ажээ. Хэлэлцээрийн үр дүнд талуудын хооронд хийгдэж буй худалдааны хэмжээ нэмэгдээд зогсохгүй хөрөнгө оруулалтын салбарт хамтран ажиллах өргөн боломж нээгдэж байгаа ажээ. Тарифын хэлэлцээрт тусгаснаар импортын бараанд ногдуулж буй татваруудын 90 хувийг харилцан тэглэх болон бууруулах талаар тусгажээ. Дээрх хэлэлцээр хэрэгжиж эхэлмэгц 10 мянган нэр төрлийн барааны ихэнхид ногдуулах татварыг шууд 59 хувиар, мөн үе шаттайгаар 30 хувиар бууруулахаар болжээ.

ЕАЭЗХ болон БНХАУ-ын хооронд чөлөөт худалдааны бүсийн хэлэлцээний эхний үе шат 2016 оны 10 дугаар сард Москва хотод болов. “ОХУ-ын Засгийн газрын тэргүүн Дмитрий Медведев, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэцян нар 2016 оны 11 дүгээр сарын 7-8-нд Санкт-Петербург хотод уулзаж, Евразийн эдийн засгийн томоохон түншлэл байгуулах хэлэлцээр байгуулах асуудлыг хэлэлцэв. ЕАЭЗХ-ны орнууд, Энэтхэг, БНХАУ, Пакистан болон бусад орнуудыг хамарсан илүү өргөн түншлэлийг бий болгох талаар хэлэлцээр байгуулах нь хэлэлцэх гол сэдэв юм” гэж ОХУ-ын Засгийн газрын нэгдүгээр орлогч Игорь И. Шувалов мэдэгдсэн байна.²³²

ОХУ, БНХАУ ЕАЭЗХ болон БНХАУ-ын хооронд чөлөөт худалдааны бүс байгуулах хоёр талын хэлэлцээр нь ийм төрлийн хэлэлцээрийн эхлэл болж магадгүй бөгөөд хэлэлцээрийг хоёр жилд багтаан байгуулах боломжтой гэж тэрбээр мэдэгдсэн байна.

2015 оны 5 дугаар сард Москвад ЕАЭЗХ, Хятадын Торгоны замын Эдийн засгийн Бүслүүр хоорондын бүтээн байгуулалт дахь хамтын ажиллагааны хамтарсан тунхаглалд гарын үсэг зурсан юм.²³³ 2017 оны 3 дугаар сард Бээжинд Хятад, ЕАЭЗХ-ны Худалдаа, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээний ажил хэрэгч бага хурал зохион байгуулагджээ. Бага хуралд: Хятадын талаас Худалдааны яам, Тээврийн яам, Гаалийн Ерөнхий газар, Оюуны өмчийн Төрийн алба, Үндэсний Оюуны өмчийн эрхийн Захиргаа болон Евразийн Эдийн засгийн комиссын Худалдааны бодлогын департамент, гишүүн орнуудын холбогдох төлөөлөгчид оролцсон байна.²³⁴

²³¹ Results of the first year of the Free Trade Agreement between Vietnam and the EAEU. 10/10/2017, Eurasian Economic Commission.

²³² EEU, China to eye FEZ creation in October 2016, First Vice Prime Minister of Russia Igor Shuvalov

²³³ Joint Statement on Cooperation on the Construction of Joint Eurasian Economic Union and the Silk Road Projects. Moscow.: May 8, 2015

²³⁴ China and Eurasian Economic Union Trade and Economic Cooperation Agreement Work Conference Negotiation Held in Beijing, March 10, 2017

Вьетнамтай чөлөөт худалдааны гэрээ байгуулсны дараа Индонез, Сингапур, Малайз, Камбож зэрэг орнууд ийм гэрээ байгуулах санал нэгэнт тавиад байна. Тэр ч байтугай Камбож улс ЕАЭЗХ-нд гишүүнээр элсэх талаар мэдээлэл авахаар албан ёсны хүсэлт тавьсан гэдгийг тэрбээр дурдсан юм. Тэрбээр “ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын хувьд АСЕАН-тай ЧХХ байгуулбал ашигтай эсэхийг судлаад эхэлсэн. Бид шинжээчдийн саналыг тусгасны үндсэн дээр удахгүй шийдвэрээ гаргана” гэж мэдэгджээ. ЕАЭЗХ ба Сингапур 2017 оны сүүлчээр ЧХХ байгуулж, 2018 оны эхний хагаст соёрхон баталж магадгүй байна гэж Игорь И. Шувалов мэдэгдэв.

“2016 оны 5 дугаар сард Сочи хотод болсон АСЕАН-ОХУ-ын уулзалтын үеэр АСЕАН-ы гишүүн орнууд ОХУ-тай ЧХХ байгуулах санал дэвшүүлсэн бөгөөд Сингапуртай ийм төрлийн хэлэлцээр тусад нь байгуулах асуудлыг нэн тэргүүний зорилт болгохыг ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин мэдэгдсэн байна. Тиймээс 2017 оны сүүлчээр Сингапуртай ЧХХ байгуулж, 2018 оны эхний хагаст соёрхон батлах боломж бололцоо бидэнд байна” гэж тэрбээр ОХУ-Сингапурын Засгийн газар хоорондын комиссын өргөтгөсөн хуралдааны үеэр мэдэгджээ.

Тэрбээр ОХУ, Сингапур нь АСЕАН дахь гол түншүүд гэж дурдаад, “цаг хугацааны асуудал хүндрэлтэй байгаа боловч хэлэлцээрийг байгуулах боломжтой. Бид өөрсдийн зүгээс чадах бүхнээ хийнэ” гэж мэдэгдсэн байна. Сингапурын Ерөнхий сайдын орлогч Гарман Шанмугаратнам, Сингапур ОХУ-тай эдийн засаг, худалдааны чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байгаа боловч хоёр улс өөрт байгаа бүх боломж бололцоогоо ашиглахгүй байна гэж мэдэгджээ.

2017 оны 6 дугаар сард Сөүл хотноо зохион байгуулагдсан Евразийн орнуудын Парламентын дарга нарын II зөвлөгөөнд оролцогчдод хандан БНСУ-ын шинээр томилогдсон Ерөнхий сайд Ий Нак-Ён БНСУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийн талаар судалж үзэхийг уриалав. “Бид Евразийн бүс нутгийн эдийн засаг, хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх ёстой” хэмээн Ий Нак-Ён онцлон хэлсэн байна. “Өмнөд Солонгосын Засгийн газар чөлөөт зах зээлийг тэлэх тухайлбал, чөлөөт худалдааны хэлэлцээрт оролцогчдын тоог нэмэгдүүлэхийг эрмэлздэг. Иймд та бүхнийг энэ асуудалд анхаарлаа хандуулахыг хүсч байна” гэж зөвлөгөөнд оролцогчдод хандан Өмнөд Солонгосын Ерөнхий сайд уриалжээ.²³⁵

ЕАЭЗХ-нд ОХУ оройлох үүрэг гүйцэтгэж байгаа нь тодорхой. Дурдсан бүс нутаг нь геостратеги, геополитик, геоэдийн засгийн асар удам оройн зай юм.

Монгол Улс, ЕАЭЗХ-ны хамтын ажиллагааны тэмүүлэл ба сорилт

Орос, Хятадын бүх талыг хамарсан хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааны шинэ өрнөлт Монголын геополитик, гео-эдийн засгийн орчныг мэдэгдэхүйц өөрчиллөө.

2015 оны 6 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд ОХУ-д айлчлах үеэрээ Евразийн эдийн засгийн комиссын СнЗ-ийн дарга В.Б.Христанкотой «Монгол Улсын

²³⁵ South Korean Prime Minister Lee Nak-yeon speech at the Annual Meeting of Speakers of Eurasian Countries' Parliaments The Korea Herald. 2017.06.27

Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны тухай Санамж бичиг»-т гарын үсэг зурснаар хамтын ажиллагааны олон улсын эрхзүйн үндэс тавигджээ. “Энэхүү санамж бичиг нь хамтын ажиллагааны эхлэл гэж дүгнэж байна” гэж тэрбээр хэлэв. Санамж бичигт зааснаар: “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комиссын хамтын ажиллагааны ажлын хэсэг” байгуулж, тарифын болон тарифын бус хориг саадыг арилгах, худалдаа ба гаалийн дүрэм журмыг хялбарчлах, бүтээгдэхүүний стандарт нормыг ижилсүүлэх, үр ашигтай, найдвартай, тогтвортой тээврийн чиглэл болон үйлчилгээг буй болгох, худалдааны тэнцвэртэй байдал, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, түүнчлэн Монгол Улс, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын ААН-ийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгох чиглэлээр арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөсөн байна.

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилын урилгаар ЕАЭЗХ-ны интеграцлал, макро эдийн засгийн асуудал эрхэлсэн гишүүн бөгөөд сайд хатагтай Татьяна Дмитриевна Валовая тэргүүтэй төлөөлөгчид 2017 оны 2 дугаар сарын эхээр Монгол Улсад ажлын айлчлал хийжээ. Төлөөлөгчдийг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил хүлээн авч уулзаж, талуудын цаашдын хамтын ажиллагааны асуудлаар хэлэлцээ өрнүүлжээ. Ц.Мөнх-Оргил Монгол Улс, ЕАЭЗХ хоорондын хамтын ажиллагаа богино хугацаанд идэвхитэй хөгжиж байгааг онцлон тэмдэглэж, тус холбоотой “Чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлэсэн байна. Т.Д.Валовая талуудын харилцааг хөгжүүлэхэд Монголын тал өндөр ач холбогдол өгч, идэвхи чармайлт гаргаж байгааг дурдаад, хамтын ажиллагааны нөөц бололцоо ихтэй бөгөөд бизнесийн төлөөлөл хоорондын уялдаа холбоог сайжруулах, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор” байгуулах зэрэг асуудлын талаар санал бодлоо илэрхийлжээ.

Талууд худалдааны харилцаан дахь мал эмнэлэг, ургамал, эрүүл ахуй, хорио цээр, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, хамтарсан сургалт, семинар, бизнес чуулга уулзалтыг Монгол Улсад зохион байгуулахаар тохиролцсон юм.

Уулзалтын төгсгөлд талууд “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсгийн II хуралдааны Протокол” болон “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комиссын хамтын ажиллагааны ажлын хэсгийн 2017-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тус тус гарын үсэг зуржээ. Дээрх баримт бичигт зам тээвэр, уул уурхай, хүнс, ХАА, бизнесийн салбар хооронд хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, туршлага солилцох, дугуй ширээний уулзалт зохион байгуулах зэрэг ажлыг тусгасан байна. Уулзалтад ГХЯ-ны төлөөлөгчдөөс гадна ОХУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд И.К.Азизов, БНБелУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд С.В.Чепурной, БНКаЗУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд К.И.Кобландин нар оролцжээ.

Айлчлалын хүрээнд төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбагад бараалхаж,²³⁶ МҮХАҮТ-д зохион байгуулах бизнес эрхлэгчдийн уулзалтад оролцож, ЕАЭЗХ, түүний үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, санал солилцсон байна.

ЕАЭЗХ-той “Чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулах нь Монгол Улс болон тус холбооны гишүүн улс хоорондын худалдаа дахь тариф болон тарифын бус хориг саадыг арилгах, Монголын уламжлалт экспортын бараа, бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлэх, худалдаа, үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татахад чухал ач холбогдолтой гэж үзэж байжээ.

Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн Комисс хоорондын Хамтын ажиллагааны ажлын хэсгийн анхдугаар хуралдаан 2015 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотноо, хоёрдугаар хуралдаан 2016 оны 11 дүгээр сард Москва хотноо тус тус амжилттай зохион байгуулагдаад байна. Эдгээр хуралдаанаар Монгол Улс болон ЕАЭЗХ-ны гишүүн улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаанд тулгарч буй тариф болон тарифын бус саад тотгорыг бууруулах, худалдааны бодлогыг харилцан уялдуулах, төрийн болон бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мал эмнэлэг, ургамал, хорио цээр болон техникийн зохицуулалтын уялдаа холбоог хангах, Монголын бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг ЕАЭЗХ-ны гишүүн улсад зохион байгуулах зэрэг асуудлыг авч хэлэлцсэн байна.

Дараалан Евразийн эдийн засгийн комиссын сайд В.Н.Корешков Монгол Улсад 2017 оны 3 дугаар сарын сүүлчээр ажлын айлчлал хийж, энэ үеэр Стандарт, хэмжилзүйн газрын удирдлагатай уулзалт хийжээ. Уулзалтын гол зорилго нь “Чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулахын тулд эхний ээлжинд хоёр талын стандарт болон техникийн зохицуулалтын баримт бичгийг судлах шаардлагатай ба энэ хүрээнд ажлын хэсэг байгуулан ажиллах, мөн хоёр талын стандарт, техникийн зохицуулалтын баримт бичгийг ижилтгэх, худалдаанд саад учруулж буй баримт бичгийн хязгаарлалтын тодорхой нөхцлүүдийг талууд зөвшилцөн нэг техникийн баримт бичиг, нэг тохирлын үнэлгээг худалдаанд хэрэглэхээр тохиролцсон байна. Стандарт, хэмжилзүйн газар Евразийн эдийн засгийн комисстой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулснаар хоёр талын харилцан

²³⁶ Монгол Улсын Засгийн газар болон ЕАЭЗХ хоорондын хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж байгаад сэтгэл хангалуун байна. Монгол Улс ЕАЭЗХ-той ЧХХ байгуулах хүсэлтэй байгаа бөгөөд энэ талын судалгааны хамтарсан баг ажиллуулахад бэлэн байгаагаа Ерөнхий сайд илэрхийлэв.

ЕАЭЗХ-ны Зөвлөлийн интеграцлал, макро эдийн засгийн асуудал эрхэлсэн гишүүн, хатагтай Валовая Татьяна Дмитриевна, Ерөнхий сайдын саналыг дэмжиж, гишүүн орнууд хамтын шийдвэрээ гаргаж, удахгүй хариу өгнө гэдгээ хэллээ. Сүүлийн жилүүдэд хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хангалтгүй, 2010 оны төвшиндөө л байна, иймд ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын болон Монгол Улсын бизнес эрхлэгчид оролцсон форум хийх хэрэгтэй байгааг хатагтай Татьяна Д.Валовая онцолсон байна. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Бизнес форум зохион байгуулахыг дэмжиж байна, талууд ярилцаад хугацаагаа товольё. Манай монголчууд бол ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын, ялангуяа ОХУ-ын бараа бүтээгдэхүүнийг хэрэглэж сурсан, чанартай гэж ойлгодог уламжлалт сэтгэлгээтэй ард түмэн. Тийм учраас таны холбооны гишүүн орнуудын хөрөнгө оруулагчид Монгол Улсад хөрөнгө оруулахад нээлттэй, зах зээлтэй, бас бэлэн хэрэглэгчидтэй. Монгол Улсын Засгийн газар ХАА-н салбараа онцгойлон авч үзэж байгаа, бүтээгдэхүүн нь цэвэр экологийн гаралтай. Эдгээр бүтээгдэхүүнээ ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад нийлүүлж гэхээр, танай стандарт өөр. Энэ бүгдээ зохицуулж зах зээлээ харилцан нээх, эдийн засаг, худалдааны салбарт элдэв хүндрэл бэрхшээлгүйгээр харилцахад

нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд техникийн баримт бичгээс шалтгаалсан хориг хязгаарлалтыг багасгах, цаашлаад “Үндэсний чанарын хөтөлбөр”-т тусгагдсан экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, сүү, арьс шир, чацаргана, зөгийн балыг гадаад зах зээлд гарахад түлхэц болж буй чухал үүргийг гүйцэтгэх ажээ. Худалдааг хөнгөвчлөх суурь болсон стандарт, техникийн баримт бичигт тавих шаардлагыг ижилтгэх, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрснөөр бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж буй төрийн бодлого, худалдаа эрхлэх боломж нөхцлийн үндсийг бүрдүүлж өгч байгаа юм.

Ази-Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссын (ESCAP) гишүүн орнуудын Тээврийн сайд нарын бага хурал Москва хотноо 2016 оны 12 дугаар сарын эхээр зохион байгуулагджээ.²³⁷ Тус бага хуралд Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат тэргүүтэй төлөөлөгчид оролцох үеэрээ Евразийн эдийн засгийн комиссын Эрчим хүч, дэд бүтцийн сайд А.О.Жунусовтой албан уулзалт хийжээ. Уулзалтаар Монгол Улс, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын тээврийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, “Монгол, Орос, Хятадын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т тусгагдсан тээвэр, дэд бүтцийн салбарын төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах талаар харилцан санал солилцжээ. Монгол Улсын ачааг ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх нөхцлийг хөнгөвчлөх, Монгол Улсын төмөр зам, авто замын дамжин өнгөрөх тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлд хамтарч ажиллахаар тохиролцсон байна. Д.Ганбат уулзалтын үеэр зам, тээврийн салбарт Евразийн эдийн засгийн комисстой хамтын ажиллагаагаа бодитоор өргөжүүлж, гишүүн улсуудаар төмөр зам, авто замаар тээвэрлэлт хийх, үнэ тарифыг багасгах, гаалийн тариф, үйл ажиллалааг хөнгөвчлөх талаар яриа хэлэлцээ хийх саналтай байгаагаа илэрхийлсэн байна. Уулзалтын үр дүнд тээврийн салбарын хамтын ажиллагааг идэвхижүүлэх эрхзүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор хоёр талын хооронд тээврийн салбарт хамтран ажиллах баримт бичгийн төслийг ойрын үед боловсруулан

²³⁷ ОХУ, Монгол, БНХАУ гурван улсын хооронд худалдааны хамтын ажиллагааны шинэ эрин үе эхэллээ. Учир нь, Азийн хурдны замын сүлжээний дагуу олон улсын тээвэр хийх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2016 оны 12 дугаар сарын 8-нд Москва хотноо байгуулсан юм. Гурван тал энэхүү хэлэлцээрийг байгуулснаараа гурван улсыг холбодог “АНЗ” болон “АН4” Азийн хурдны замын маршрутын дагуу олон улсын зам тээврийн үйл ажиллагаа явуулах эрхийг нөгөө хоёр улсдаа олгож байгаа юм. Гишүүн орнууд Азийн хурдны замын сүлжээг ашиглах бөгөөд энэ нь худалдаа наймаа, ард иргэдийн хоорондын харилцааны асуудалд түлхэц үзүүлэх, ялангуяа далайд гарцгүй Монгол Улсад эдийн засгийн хувьд ихээхэн өгөөжтэй юм гэж НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч бөгөөд Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын / ESCAP/ нарийн бичгийн дарга, доктор Шамшад Ахтар мэдэгдэв. Уг хэлэлцээрийг байгуулах хэлэлцээг талууд гурван жилийн турш хийсэн бөгөөд үүнд “ESCAP” техникийн тусламж үзүүлсэн байна. Энэ санаачилгын үр өгөөжийг харуулахын тулд 2016 оны оны 8 дугаар сард гурван орны тээврийн яамд 9 ачааны машинаас бүрдэх цувааг БНХАУ-ын Тяньжин боомтоос Улаанбаатар, Улаанбаатараас ОХУ-ын Байгал нуурын эрэг дэх Улаан-Үд хот хүртэл 2150 км аялуулах загвар арга хэмжээг зохион байгуулжээ. Уг хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Пакистантай залгаа хил дэх “АН4” хурдны замын маршрутыг нээж, цаашдаа уг замыг Хятад-Пакистаны эдийн засгийн коридорын дагуух Төв Азийн орнуудтай хоёр болон дөрвөн талт хэлэлцээрүүдийн дагуу холбох юм. Ингэснээр “Торгоны их зам” эдийн засгийн бүслүүрийн баруун коридорыг байгуулах боломжтой болно. Үүний зэрэгцээ хэлэлцээрийн хүрээнд “АНЗ” хурдны зам буюу Улаан-Үд-Улаанбаатар-Бээжингээс Тяньжин боомт хүртэл, “АН4” буюу Новосибирск-Өрөмч- Каши-Хонкираф хүртэлх хурдны замуудыг нээсэн нь БНХАУ-Монгол-ОХУ-ын эдийн засгийн гурван талт хамтын ажиллагаанд гарсан бодит ололт юм. Азийн хурдны замын маршрутын дагуу дамжин өнгөрүүлэх тээвэрлэлтийн эрх солилцох хүсэлтэй байгаа бусад орнууд энэхүү хэлэлцээрт нэгдэх боломжтой ажээ.

хэлэлцэж, хамтарсан ажлын хэсэг байгуулахаар тохиролцсон нь ач холбогдолтой болжээ.

Монгол Улсын ГХЯ, Евразийн эдийн засгийн комисс болон МҮХАҮТ хамтран 2017 оны 10 дугаар сард “Монгол Улс ба Евразийн эдийн засгийн холбоо-2017” анхдугаар бизнес чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулжээ. Энэхүү чуулга уулзалтад ГХ-ны сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Мөнх-Оргил, Евразийн эдийн засгийн комиссын Техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн сайд В.Н.Корешков, Эрчим хүч, дэд бүтцийн асуудал эрхэлсэн сайд А.О.Жунусов тэргүүтэй төлөөлөгчид мөн Монголын талаас ЗТХЯ, ЭХЯ, СХЗГ, МХЕГ, МЭҮГ, ҮХГ-ын удирдлага, ОХУ, БНБеларусьУ, БНКазахстанУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд нар, түүнчлэн Монгол Улс, ОХУ, БНБеларусьУ, БНКазахстанУ-ын бизнес эрхлэгчид зэрэг нийт 200 гаруй төлөөлөгч оролцов.

Бизнес чуулга уулзалтын үеэр “Монгол Улс-ЕАЭЗХ: хөрөнгө оруулалт, зам тээвэр, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа ба хэтийн төлөв”, “Монгол Улс – ЕАЭЗХ: Техникийн зохицуулалт, эрүүл ахуй, ургамлын хорио цээр ба мал эмнэлгийн салбарын хамтын ажиллагааны хэтийн төлөв” сэдвийн дор 2 салбар хуралдаан болж, зөвхөн бизнесийн салбарын хамтын ажиллагаа төдийгүй дэд бүтэц, хөрөнгө оруулалт, техникийн зохицуулалт, эрүүл ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломж, арга замын талаар төрийн байгууллагуудын болон бизнес эрхлэгчдийн хооронд санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүлэв.

ЕАЭЗХ-той уул уурхайн бус бүтээгдэхүүн экспортлох хамтын ажиллагаатай. Энэ хамтын ажиллагааны хүрээнд ЕАЭЗХ-той хамтран анхдугаар бизнес чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Чуулга уулзалтаар хоёр талын бизнесийн түншүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, төр хоёр талын бизнес эрхлэгчдийг холбоход тулгамдаж буй асуудал, цаашид шийдвэрлэх боломжтой хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Тухайлбал, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад экспортлох бараа, бүтээгдэхүүнд тавигдах стандарт, шаардлага, техникийн зохицуулалт, эрүүл ахуйн шаардлага ямар байх ёстойг танилцуулж, хамтран ажиллах санамж бичгүүдэд гарын үсэг зурсан юм.

Уул уурхайн бус бүтээгдэхүүн экспортлох хэлэлцээртэй Евразийн эдийн засгийн холбоотой хамтран ажиллах хүрээгээ тэлэх, шинэ боломжуудыг эрэлхийлж ажиллах нь зүйтэй гэж талууд үзэж байгаа юм.

Евразийн эдийн засгийн комиссын Техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн сайд В.Н.Корешков: “Одоогоор Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 40 компани, хөнгөн үйлдвэрийн 18 аж ахуйн нэгж ЕАЭЗХ-ны зах зээлд бараа бүтээгдэхүүн нийлүүлэх зөвшөөрөл авсан. Холбооны таван улс, Монголын талаас бараа бүтээгдэхүүн авах. танайхаас нийлүүлэх хүсэл сонирхол нэг байгаа. Тиймээс бидний ажил урагшилна гэдэгт найдаж байна” хэмээн онцоллоо.

Монгол Улсын экспорт, импортын барааны нэр төрөл, тоо хэмжээ буурч байгаа нь худалдаан дахь хориг саад их байгаатай холбоотой аж. Тухайлбал, ЕАЭЗХ-ноос

Монголын гол нэр төрлийн экспортын бараа бүтээгдэхүүнд 15-20 хувийн гаалийн татвар, 12-20 хувийн нэмүү өртгийн албан татварыг тус тус ногдуулдаг. Түүнчлэн мал эмнэлэг хорио цээрийн тусгай нөхцөл, стандарт техникийн хатуу зохицуулалт, тээвэр ложистикийн зардал зэрэг Монголын бараа, бүтээгдэхүүн, дээрх зах зээлд гарахад олон саад бэрхшээл бий.

Монголын үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгжүүд бараа бүтээгдэхүүнийхээ чанар, сав баглаа, боодолд ЕАЭЗХ-ноос тавигдаж буй техникийн шаардлага, стандартад нийцүүлж үйлдвэрлэж чаддаггүй явдал ч байгаа аж. Эдийн засгийн чуулга уулзалтууд болж байгаа нь сайн ч, үр дүн нь Монголын эдийн засагт эергээр нөлөөлж байх ёстой. Тиймээс энэ удаагийн чуулга уулзалтаар санамж бичиг байгуулан саад бэрхшээлийг арилгахад хамтарч ажиллахаар санал нэгдэж байгаа нь нэг том үр дүн болж байгааг талууд тэмдэглэж байна.

Гурван улсын эдийн засгийн коридор бол ЕАЭЗХ, Торгоны замын нэг зам, бүслүүр, Монголын “Хөгжлийн зам” хөтөлбөрийн интеграцийг хэрэгжүүлж, хоршин хөгжих явдалд оршино. 2017 оны 8 дугаар сард Москвад зохиогдсон гурван улсын шинжээчдийн түвшний II уулзалт чухал үе шат болов.

Тус уулзалтаар Монгол Улсын ГХЯ, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил шинэчлэлийн хороо хооронд Монгол, Орос, Хятадын “Эдийн засгийн коридор”-ын хэрэгжилтийг урагшлуулах хамтарсан механизм байгуулах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн агуулгыг тохиролцож, гарын үсэг зурж, талууд “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т тусгагдсан 32 төслөөс тэргүүлэх ач холбогдол өгч эхний ээлжид хэрэгжүүлэх төслүүдийн талаар хэлэлцэж, нэгд, төмөр замын төв коридор, *хоёрт*, авто замын төв коридор байгуулах, Монгол, Оросын цахилгаан эрчим хүчний сүлжээг шинэчлэхэд Хятадын аж ахуйн нэгжүүд оролцох боломжийг судлах зэрэг 3 төслийг энэхүү санамж бичгийн хавсралтад оруулсан байна. Талуудын тохиролцсон анхны төсөл хэрэгжиж эхлэхэд “Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төв”-ийг Улаанбаатар хотноо байгуулж ажиллахаар гурван тал санал нэгджээ.

Дүгнэлтийн оронд: ЧХХ ба сорилт

Дэлхий нийтийн хэмжээнд олон талт чөлөөт худалдааны хэлэлцээр, эдийн засгийн интеграци тодорхой сорилтуудтай тулгарсаар байна. Даяаршлын үйл явц, харилцан хамаарал давуу болон эмзэг байдлаа харуулсаар байна. АНУ Номхон далайн түншлэлийн хэлэлцээрээс гарч, НАФТА болон Трансатланитикийн гэрээг шинэчлэх, БНСУ-тай ЧХХ-г эргэж харах, ЕХ-ны орнууд илүү олон сорилттой тулгарч байна. Энд Евро бүсийн орнуудыг хэлэхэд хангалттай. BREXIT олон асуудлыг шинээр үүсгэж байна. Ер нь эдийн засгийн интеграци, ЧХХ бол цорын ганц боломж биш гэдэг нь тодорхой болсоор байна.

Олон улсын худалдааг хөгжүүлж, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, худалдааг хөнгөвчлөхөд ДХБ-ын дүрэм журмын хүрээнд хоёр болон

олон талт ЧХХ-ийг байгуулах, нэгдэн ороход ач холбогдолтой. Гэхдээ энэ нь экспортын чадавх сайтай улс орнуудад илүү үр өгөөжөө өгч байгаа юм.

Бид ЕАЭЗХ-той ЧХХ байгуулсан тохиолдолд гишүүн таван орны бараа бүтээгдэхүүн Монголын зах зээлд гаалийн тариф үе шаттайгаар буурсаар орж ирэхэд манай үндэсний үйлдвэрийн өрсөлдөх чадвар түүнийг тэсч үлдэх үү? гэдэг зарчмын асуудал байгаа юм. Зөвхөн улаан буудайн импортын талаар ярихад л том асуудал үүснэ. Монгол Улс ЕАЭЗХ-д уул уурхайн бүтээгдэхүүн экспортлохгүй нь тодорхой. Мах бол хязгаартай бүтээгдэхүүн. Монгол Улс АПЕК-г гишүүнээр элсэхээр зорьж байгаа билээ. Гэхдээ АПЕК шинээр гишүүн орон элсүүлэхээ хойшлуулсан байгааг бид мэднэ. Хэрэв Монгол Улс АПЕК-гишүүнээр элссэн тохиолдолд 2020 он гэхэд хүссэн эс хүссэн худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчилах нь тодорхой. Мөн бид БНСУ, БНХАУ-тай ЧХХ байгуулахаар ажиллаж байгаа билээ. Үүнийгээ бид Монголын уламжлалт экспортын бараа, бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлэх гэдгээр тайлбарладаг. Зах зээл бидэнд хангалттай. Харин Монгол Улсын эдийн засгийн чадавх, өрсөлдөх чадвар сул, гарц бага юм. Тухайлбал, Японтой байгуулсан Эдийн засгийн түншлэлийн Ерөнхий хэлэлцээр 2016 оны 6 дугаар сард хүчин төгөлдөр болсон ч Монголын экспорт нэмэгдсэнгүй.

Их биш боловч гаалийн татвар Монгол Улсын хувьд төсвийн орлогыг бүрдүүлдэг нэг эх сурвалж байтал ЧХХ байгуулснаар гаалийн татвар буурах нь тодорхой. 1997 онд гаалийн татварыг тэглэснээр үндэсний үйлдвэрлэл, газар тариалан уналтанд орж байсан билээ.

Монгол Улс олон улсын байгуугууллагад гишүүнчлэлтэй болох гэж ихээхэн хичээдэг. Түүний үр өгөөж чамлалттай. Монгол Улсын санаачилгаар эхэлсэн гурван хөршийн саммитын агуулга нь цаашдаа зөвхөн хөрш хоёр гүрний худалдаа-эдийн засгийн бодлогод Монгол Улсыг хэрхэн яаж оролцуулах асуудлыг хэлэлцдэг механизм байж таарахгүй нь мэдээж төдийгүй, улам өргөн хүрээтэй асуудал хэлэлцдэг байх шаардлагатай нь харагдаж байгаа юм. Гурван улсын эдийн засгийн коридор байгуулах, ЕАЭЗХ, БНСУ, БНХАУ-тай ЧХХ байгуулах, ШХАБ-д элсүүлэх санал, гурван хөршийн саммитын *moratorium* томоохон сорилт бөгөөд 2012 оны 12 дугаар сард ЕАБХАБ-ын 57 дахь гишүүнээр элссэн анхны Дорно дахины орон болсон. Тийнхүү Атлант, Газрын дундад тэнгис, Евразийг дамнасан Ванкувэрээс Владивосток хүртэл аюулгүй, тогтвортой байдлыг хангах механизм болон хөгжив. Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангах зорилтыг хэрэгжүүлэхэд ЕАБХАБ-тай тогтоосон харилцаа чухал ач холбогдолтой гэж үзсэн ч тус байгууллага Украины хямрал, Крымын хойгийг Орос хүч түрэн өөртөө нэгтгэхэд юу ч хийж чадаагүй билээ. Эцэст нь тэмдэглэхэд Монгол Улс ЧХХ-ийн оронд Эдийн засгийн түншлэлийн Ерөнхий хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллаж, мөн ч судалгаа, дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийх нь нэн чухал болой.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ.: 2011
2. «Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны тухай Санамж бичиг» УБ.:2016
3. Договор о Евразийском экономическом союзе. М.: 2015 (на монгольском и русском языке)
4. Васильева Н. А., Лагутина М. Л. Формирование Евразийского союза в контексте глобальной регионализации (недоступная ссылка) // Евразийская экономическая интеграция, № 3 (16), 2012.
5. Lagutina M. Eurasian Economic Union Foundation: Issues of Global // Eurasian Border Review, Spring 2014